

ЗАХИАЛАГЧААР БАТЛАГДСАН АЖЛЫН ДААЛГАВАР

Тендер шалгаруулалтын
нэр, дугаар:

“Цаг уурын автомат станцаар хангах (Говь-Алтай-2,
Ховд аймаг-2)” № БОЯБХУАӨДЗТөсөл/20240902007

№	Ажлын нэр, төрөл	Тайлбар
1.	Төслийн зорилго	<p>Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Монгол Улсын Засгийн газар хоорондын хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд Германы Сэргээн босголт, Зээлийн банк (KfW)-аар дамжуулан “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн 2, 3-р үе шатыг БОАЖЯ-тай хамтран 2020 оны 3-р сараас хэрэгжүүлж байна.</p> <p>Төслийн зорилго: Монгол орны ТХГН-ийн сүлжээнд (Орчны бүс нутаг болон Орон нутгийн захиргаад, иргэд) чухал ач холбогдол бүхий газруудын үр ашигт байдал, тогтвортой менежментийг сайжруулах, нутгийн иргэдийн тогтвортой амьжиргааны шинэ эх үүсвэрүүдийг бий болгоход дэмжлэг үзүүлэх юм. Төсөл нь 4 үндсэн бүрэлдэхүүн хэсэгтэйгээр хэрэгжинэ. Үүнд:</p> <p><u>Бүрэлдэхүүн хэсэг 1:</u> ТХГН-ийн болон (орчны бүс, эко-холбоос нутгуудыг хамруулан) менежментийн ба бизнесийн төлөвлөлтийг Олон улсын байгаль хамгаалах холбооны (ОУБХХ-IUCN) удирдамж, стандартын дагуу боловсруулах, шинэчлэн сайжруулах, ТХГН-ийн сүлжээний хэмжээнд менежментэд шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах;</p> <p><u>Бүрэлдэхүүн хэсэг 2:</u> Газарзүйн томоохон бүс нутаг буюу төсөлд хамрагдсан ТХГН-ийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, шаардлагатай хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх;</p> <p><u>Бүрэлдэхүүн хэсэг 3:</u> Тогтоосон шалгуурын дагуу сонгосон бие даасан 7 ТХГН-ийн менежментийн болон бизнес төлөвлөгөөг нь сайжруулж, хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх;</p> <p><u>Бүрэлдэхүүн хэсэг 4:</u> ТХГН-ийн сүлжээний хэмжээнд чадавхыг дээшлүүлэх, олон нийтэд таниулан сурталчлах арга хэмжээнүүдийг зохион байгуулах;</p>

2.	Ажлын үндэслэл, зорилго	<p>БОЯБХУАӨДЗ төслийн 2,3-р үе шатанд Монгол орны баруун хэсэгт УТХГ-ууд тэдгээрийн орчны бүс, экологийн коридорыг хамруулан газар зүйн томоохон бүсийг хамруулан биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон менежментийг хэрэгжүүлэх, нутгийн иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжих үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>Аймгуудын Ус цаг уур орчны шинжилгээний төвүүд нь сум бүрт цаг уурын автомат станц суурилуулснаар уур амьсгал, хөдөө аж ахуй, ус судлалын чиглэлээр Дэлхийн цаг уурын байгууллагын өмнө хүлээсэн үүргийнхээ дагуу ард иргэдийг цаг агаарын мэдээ, мэдээллээр тасралтгүй хангахаас гадна аймгийн хэмжээнд бэлчээрийн даац багтаамж тогтоох, болон цөлжилтийн ажиглалт, хэмжилтийг хийж байгаль орчны төлөв байдлын судалгааг иж бүрэн гүйцэтгэдэг.</p> <p>Ард иргэдийг цаг агаарын мэдээллээр хангах, бэлчээр талхлагдал, доройтол, хөрсний элэгдэл, эвдрэл, ургамлын зүйлийн бүрдлийг тооцож гаргах, байгаль орчны ажиглалт мониторингийн ажлыг гүйцэтгэхэд стандарт технологийн горимыг хангахуйц цаг уурын ажиглалтын орчин үеийн өндөр нарийвчлалтай багаж хэрэгсэл аймгуудад ихээхэн дутагдалтай байна.</p> <p>Ховд, Говь-Алтай аймгуудын УЦУОШТ-үүдээс ирүүлсэн хүсэлтийг үндэслэн орчин үеийн дэвшилтэт технологи бүхий техникийн үзүүлэлт өндөртэй "Цаг уур орчны шинжилгээний автомат станц"-уудыг нийлүүлэхэд энэхүү худалдан авах ажиллагааны үндэслэл, ажлын даалгаврын зорилго оршино.</p>
3.	Хамрах хүрээ	БОЯБХУАӨДЗ төслийн 2,3-р үе шатанд хамрагддаг Ховд, Говь-Алтай аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв (УЦУОШТ)
4.	Хүлээн авах бараа, тоо ширхэг	<p>Нэг төрлийн 4 ширхэг Цаг уурын автомат станцыг захиалагчид хүлээлгэн өгнө Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Ховд аймгийн УЦУОШТ -2 ширхэг - Говь-Алтай аймгийн УЦУОШТ -2 ширхэг <p>(Техникийн тодорхойлолтыг Ажлын даалгаврын нэгдүгээр хавсралтаас харна уу)</p>

5.	Хийх ажлын иж бүрдэл	<ul style="list-style-type: none"> - Гэрээнд заасан тоо, чанар, техникийн үзүүлэлт бүхий Цаг уурын автомат станцыг гэрээний хугацаанд нийлүүлэх ба Ховд, Говь-Алтай аймгуудын төвүүдэд тээвэрлэн хүргэж, УЦУОШТ-д хүлээлгэн өгнө. - Цаг уурын автомат станцын ашиглалт, засвар арчилгаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон аргазүйн сургалт зохион байгуулах, - Сургалтын үеэр болон цаашид ашиглалтын үед шаардлагатай мэдээлэл агуулсан гарын авлага, материал, хэрэглэгдэхүүнийг Монгол хэл дээр бэлтгэж бараа бүтээгдэхүүний хамт хүлээлгэн өгнө.
6.	Ажил гүйцэтгэх хугацаа	<p>Гэрээнд гарын үсэг зурснаас хойш 150* хоногийн хугацаанд хийж гүйцэтгэнэ.</p> <p>*Гэрээний нийт үргэлжлэх 150 хоногийн хугацаанд Гэрээлэгч зөвлөх захиалагч талд гэрээгээр хүлээсэн ажлыг хүлээлгэн өгч, акт үйлдэж, эцсийн төлбөрийг гэрээлэгчийн дансанд шилжүүлсэн байхаар тооцсон хугацаа болно.</p>
7.	Хүрэх үр дүн	<ul style="list-style-type: none"> ✓ Аймгуудын УЦУОШТ-үүд цаг уурын мэдээлэл цуглуулах, боловсруулах, ард иргэдийг цаг агаарын мэдээллээр хангах, зарлан мэдээлэх байгалийн гамшигт үзэгдлээс сэргийлэх, сөрөг үр дагаврыг бууруулах чадавх сайжирна, ✓ Бэлчээр талхлагдал, доройтол, хөрсний элэгдэл, эвдрэл, ургамлын зүйлийн бүрдлийг тооцож гаргах, байгаль орчны ажиглалт мониторингийн ажлын чанар дээшилнэ, ✓ Төслийн бүс нутагт Уур амьсгалын өөрчлөлтийн мэдээллийн сан бүрдүүлэхэд хувь нэмэр оруулна,
8.	Тендерт оролцогчид тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> ➤ "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн шинэчилсэн найруулгаар Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.1-д заасныг үндэслэн захиалагчийн тогтоосон чадавхын шаардлага; ➤ Техникийн тодорхойлолт; ➤ Тендерийн баримт бичигт заасан Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн Босголтын Зээлийн банк (KfW)-ны бусад нөхцөл, шаардлага;
9.	Захиалагч байгууллага	Байгаль орчин, аялал жуулчлалын яам,

10.	Санхүүжилтийн эх үүсвэр	Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд Сэргээн Босголт, Зээлийн банк (КfW)-аар дамжуулан БОАЖЯ-ны хэрэгжүүлж буй “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III” BMZ 201667054, 201868272 төсөл.
11.	Нийт санхүүжилт	438,358,800.00 (дөрвөн зуун гучин найман сая гурван зуун тавин найман мянга найман зуун) төгрөг
12.	Худалдан авах ажиллагаанд дагаж мөрдөх хууль, дүрэм, журам	<ul style="list-style-type: none"> • Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн Босголт Зээлийн банк (КfW)-ны “Түншлэгч улсуудтай хийх санхүүгийн хамтын ажиллагааны хүрээнд зөвлөх үйлчилгээ, ажил, үйлдвэрийн байгууламж, барааны болон зөвлөх бус үйлчилгээ худалдан авах ажиллагааны журам”; • Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн Босголт Зээлийн банк (КfW)-ны БОНМБ-ын шаардлага, стандартууд; • Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн Босголт Зээлийн банк (КfW)-аар батлагдсан бараа нийлүүлэх тендерийн баримт бичиг; • Захиалагчаар батлагдсан тендерийн баримт бичиг болон ажлын даалгавар;

“Цаг уурын автомат станцаар хангах (Говь-Алтай-2, Ховд аймаг-2)” БОЯБХУАӨДЗТөсөл/20240902007 дугаарт тендер шалгаруулалтын ажлын даалгаврын Нэгдүгээр хавсралтаар тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолтыг батлав.

-----oOo-----

ЗАХИАЛАГЧААР БАТЛАГДСАН АЖЛЫН ДААЛГАВРЫН НЭГДҮГЭЭР ХАВСРАЛТ

“ЦАГ УУРЫН АВТОМАТ СТАНЦААР ХАНГАХ (ГОВЬ-АЛТАЙ-2, ХОВД АЙМАГ-2)”
ТЕНДЕРЭЭР НИЙЛҮҮЛЭХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Худалдан авах барааны нэр		Цаг уурын автомат станц	
Худалдан авах тоо (Ширхэг)		4 (дөрөв)	
Нэг. Цаг уурын автомат станцын мэдрүүр			
1	Агаарын чийг, температурын мэдрүүр: /IEC 60751 стандартад нийцсэн/;		
	Агаарын температур мэдрэгч элемент	Pt100 RTD	
	Хэмжих хязгаар	-80 ⁰ C ÷ + 60 ⁰ C	
	Алдаа: -80 ⁰ C ... + 20 ⁰ C +20 ⁰ C ... +60 ⁰ C	±(0.226 - 0.0028 х температур) °C ±(0.055 + 0.0057 х температур) °C	
	Агаарын чийгийн мэдрэгч элемент	HUMICAP®	
	Хэмжих хязгаар	0 ÷ 100%	
	Алдаа	± 2%, RH=0...90% ± 3%, RH=90...100%	
	Гаралтын хүчдэл	0...1 вольт	
	Ажиллах хүчдэл	7...28 вольт	
	Уг мэдрүүр нь цацрагийн хамгаалалтай байна./ radiation shield/ Цацрагийн хамгаалалтын хийц нь ямар ч цаг агаарт хэмжлийн нөхцөлийг хангана. Температурын нөхүүрт толгойтой, 2 м урт кабель, холбогчтой. Инерцийн хугацаа 2 секундээс бага.		
2	Агаарын даралт		
	Мэдрэгч	BAROCAP®	
	Хэмжих хязгаар	500-1100 гПа	
	Алдаа, жил ажиллахад, %	≤ ±0,2	
	Нарийвчлал	0,10	
Ажиллах орчин	-40 ⁰ +60 ⁰ C		
3	Хөрсний гадаргын температур:		
	Мэдрэгч	PT100 цагаан алтаар хийсэн байна	
	хэмжих хязгаар	-60 ⁰ C ... +80 ⁰ C	
	Алдаа	0,385 ом/ ⁰ C	
15 м кабель, холбогч, Зэвэрдэггүй ган толгойтой			
4	Салхи	Хурд	Зүг
		0,4÷75 м/с	0-360 ⁰
		±0,17 м/с (см хаз)	≤ ±3 ⁰
5	Нарийвчлал	0,1 м/с	5,6 ⁰
		U=0.328+0.101*R	
		<0,4 м/с	
		-50 ⁰ C ÷ +50 ⁰ C	

6	Халаагч	20V, 500ma (мэдрүүр бүрт)
	Мэдрүүрүүдийн холболтын хайрцаг бүхий суурь, логгерт холбох 10 м-ээс дээш утастай	
7	Хур тунадас: /шингэн тунадас хэмжих зориулалттай/	
	Нарийвчлал	0,2 мм
	Алдаа, %	< ± 1% (<25 мм/ц) < ± 5% (<120 мм/ц)
	Хэмжих хязгаар	0,2-250 мм/ц
	Хүлээн авах талбайн хэмжээ	400 см ²
	Жин	≤1000 гр
	Ажиллах орчин	-40 ⁰ C +55 ⁰ C
Хоёр. Datalogger /Төв тооцоолуур/		
1	Ажиллах температур	-50 ⁰ C +60 ⁰ C
2	Процессор	33 MHz, 32-bit, 4MB RAM and 4 MB program flash, 3.3 MB internal flash memory, Up to 2GB on optional, compact, flash memory card
3	Мэдрүүрийн оролт	10 аналог оролттой (20 single-ended inputs) 2 counter/frequency оролтууд
4	Тэжээл	8-30 вольт /ТОГТМОЛ/ Илүүдэл хүчдэлээс хамгаалсан байна. /Surge arrester, Mains filter/ Нарны хавтан холбох боломжтой байх
5	Ажиллах чийг	0 - 100%
6	Дотоод санах ой	7 хоногийн мэдээ хадгалах
7	Гадаад санах ой	≥2 Gb Compact memory flash card
8	Холболт	RS232 , RS485/2 утсаар/ мөн SDI12 DSI486 модультай; RS485-ийн шугам хамгаалалттай байна./Surge arrester/; Хурд: 300-38400 bps; Сүлжээгээр мэдээллийг авдаг байх /Ethernet module, Surge arrester/;
9	Хурд	300 - 19200 bps;
10	Дотоод тэжээлийн эх үүсвэр	24 цагаас дээш / Logger ажиллах /

11	<ul style="list-style-type: none"> - Тоос шороо болон чийгээс хамгаалагдсан тусгаарлалтын хайрцагтай байх; - Гаднын туслах төхөөрөмжгүйгээр бүх мэдээг харах болон шаардлагатай үед тохируулга хийх боломжтой LCD дэлгэцтэй байх; - Дэлгэцээс мэдрүүлүүдийн тоололтуудыг авч болдог байх; - Суурин компьютерт холбогдож болдог байх; - GSM/GPRS модемтой байх; - RS232↔RS485 конвертор; - Гадаад санах ойнд мэдээ хадгалах 1 ширхэг; - Бүх тохиргоо хийгдсэн, шаардлагатай конфигурацаар хангана;
<i>Гурав. Шон</i>	
1	<ul style="list-style-type: none"> - Өндөр 10 м; - Зориулалтын хөнгөн цагааны хайлш /Aluminum alloy/ аар хийгдсэн байх; - Аянга зайлуулагчтай байх; - Сууриараа эсвэл 2 м орчим буулгах, босгох нугастай байх - Орой болон дунд хэсгээсээ татуургатай байна. / бш/ - Цагаан эсвэл улаан цагаан хосолсон өнгөтэй байна - Суурь болон татуургын зангатай байна.
<i>Дөрөв. Бусад</i>	
1	<ul style="list-style-type: none"> - Vaisala эсхүл түүнтэй дүйцэхүйц; - ISO 9001:2015 буюу үйлдвэрлэсэн улсын хүчин төгөлдөр чанарын стандартын гэрчилгээтэй байх; - Баталгаат хугацаа: 12 сараас доошгүй байх;

-----oOo-----